



ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо: 2024.02.05

№ 06

Улаанбаатар хот

### “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, 73 дугаар зүйлийн 73.11 дэх хэсэг, “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.12 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын эчнээ санал хураалтын Тооллогын комиссын 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журамд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалтыг нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг:

“5.4. Зөвлөлийн гишүүн биеийн эрүүл мэндийн байдал, эсвэл хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар зөвлөлийн гишүүний үүргийг цаашид гүйцэтгэх боломжгүй гэж үзэж, чөлөөлөгдөх хүсэлтийг Зөвлөлийн даргад гаргасан, эсхүл энэ журамд заасан холбогдох шалгуурыг хангахгүй болсон, зөвлөлийн хуралд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2-оос дээш удаа оролцоогүй тохиолдолд Зөвлөлийн дарга энэ тухай ТУЗ-д мэдэгдэнэ.”

2/5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг:

“5.5. Энэ журмын 5.4 дэх хэсэгт заасны дагуу Зөвлөлийн даргаас ирүүлсэн мэдэгдлийг үндэслэн Хяналтын зөвлөлийн гишүүнийг Хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хуралд нэр дэвшүүлэх сонгон шалгаруулалтыг явуулна.”

2. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын 2 дугаар зүйлийн 2.2.1 дэх заалтын “эзэмшдэггүй” гэсний дараа “иргэн” гэж нэмсүгэй.

3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын 2 дугаар зүйлийн 2.2.2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/2 дугаар зүйлийн 2.2 дахь заалт:

“2.2.2.Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь банктай сүүлийн 2 (хоёр) жилийн хугацаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан худалдан авах ажиллагааны харилцаа, хөдөлмөрийн харилцаанд оролцоогүй байх;”

4. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын 2 дугаар зүйлийн 2.4.6 дахь заалтын “тооцож Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулна” гэснийг “тооцно” гэж өөрчилсүгэй.

5. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын 2 дугаар зүйлийн 2.2.1, 2.4.1, 2.4.3, 2.4.4, 2.4.5, 2.4.6, 2.4.7 дахь заалтын “ээлжит” гэснийг тус тус хассугай.

6. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын эчнээ санал хураалтаар гаргасан шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад, нээлттэй мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Э.Уянга)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН